

ГОВЬСҮМЭР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/2



www.nso.mn, govisumber.nso.mn, www.1212.mn



www.1212.mn



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН**



www.nso.mn сайтын
Хэрэглэгийн бүртгэлд
бүртгүүлснээр
цахим хаягаар
тогтмол авч болно.



Monstat ezStat
аппликейшн



1900-1212



Лавлах утас

**Үндэсний
Статистикийн
хорооны
НОМЫН САН**

@statistic_mn



Статистик
мэдээлэл



Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВЛИГА

ҮГҮЙ

НЭЭЛТТЭЙ

ХҮРГЭНЭ



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	
Аргачлалын тайлбар.....	
I.Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III.Эрүүл мэнд	
IV.Гэмт хэрэг	
V.Үнэ.....	
VI.Төсөв.....	
VII.Хөдөө аж ахуй	
VIII. Аж үйлдвэр	
IXI.Тээвэр.....	
XI. Холбоо.....	
XII.Цаг агаарын мэдээ.....	
Хавсралт.....	

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараахь тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:**

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

- **Нийгмийн даатгал, халамж:**

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийг нхариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэрхэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.



✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг гнэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг СанхүүТөрийн сангийн Хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 2 дугаар сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 2 дугаар сард 254 болсноос 146 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 135 нь ажилгүй иргэд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57 буюу 18.3 хувиар, өмнөх сарынхаас 47 ажил хайгч буюу 15.6 хувиар тус тус буурсан байна.

Эхний 2 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 34 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 17 буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн хэлтсээр эхний 2 сард 14 иргэн ажилд зуучлуулсны 8 нь буюу 57.1 хувь эмэгтэйчүүд байлаа.

Зураг.I.1

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй,
жил бүрийн эхний 2 дугаар сарын байдлаар



Ажил хайгч ажилгүй иргэдийн 53.1 хувийг бүрэн дунд, 22.4 хувийг дипломын болон бакалаврын, 9.1 хувийг техникийн болон мэргэжлийн, 7.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.3 хувийг бага боловсролтой, 2.4 хувийг суурь, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэл, Статистикийн газрын иргэний бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 2 дугаар сард 66 эх амаржиж, 67 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо болон мэндэлсэн хүүхдийн тоо 2 буюу 3.1 хувиар өссөн байна.


2016 оны эхний 2 дугаар сард нас баралт 19, бүртгүүлсэн гэр бүл 8, цуцалсан гэр бүл 3, үрчлэгдсэн хүүхэд бүртгэгдээгүй ба өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 4 буюу 35.7 хувиар өссөн, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 27.3 хувиар, цуцалсан гэр бүл 1 буюу 25.0 хувиар тус тус буурсан байна.



Тайлант хугацаанд 133 иргэн нийслэл болон бусад аймгуудаас шилжин ирж, 76 иргэн нийслэл болон бусад аймаг руу шилжин явсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн иргэн 25 буюу 23.1 хувиар өсч, шилжин явсан иргэн 4 буюу 5.6 хувиар өссөн байна.

Зурар.1.3

Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 2 дугаар сард 754.1 сая төгрөг, зарлага 1386.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 461.8 сая төгрөг буюу 38.8 хувиар буурч, зарлага 191.2 сая төгрөг буюу 15.9 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 2 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 461.8 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн даатгалын сангийн орлого 274.6 сая төгрөг буюу 36.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 2 дугаар сард 1386.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 191.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 141.3 сая төгрөг буюу 15.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 2 сард 2023 хүнд 195.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 284 хүн буюу 12.3 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 88.5 сая төгрөг буюу 31.1 хувиар тус тус буурсан байна. Нийгмийн халамжийн сан буурахад алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж олгогдоогүй нь голлон нөлөөлсөн байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 2 сард 923 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 44 хүн буюу 4.5 хувиар буурсан хэдий ч олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 8.0 сая төгрөг буюу 6.3 хувиар өссөн байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжинд 2016 оны эхний 2 сард 1100 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 240 хүн буюу 17.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




II.3 Дундаж цалин

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эхний 2 сарын мэдээгээр 162 байгууллагын 3264 даатгуулагч иргэн, үүнээс 341 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуудагчдын цалин өссөн дүнгээр 6.1 тэрбум төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч орсон дүнгээр 492.4 мянган төгрөг, сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 510.4 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуй нэгжийн 1074 даатгуулагчийн дундаж цалин нь 783.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын 1455 ажилтны цалин дундаж цалин нь 694.7 мянган төгрөг, 6 ХКомпанийн дундаж цалин нь 707.7 мянган төгрөг, 64 ХХКомпанийн 549 ажилтны цалин дундаж цалин нь 495.5 мянган төгрөг, бусад 18 байгууллагын 112 ажилтны дундаж цалин нь 487.5 мянган төгрөг боллоо.

Зураг II.1

Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны эхний 2 дугаар сарын байдлаар




III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 2 сарын байдлаар 59 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 58 үүнээс 32 нь эрэгтэй, 26 нь эмэгтэй, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 8 буюу 11.9 хувиар, хүүхэд 8 буюу 12.1 хувиар тус тус буурсан байна.

Зураг III.1

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 2 сарын байдлаар






0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 ба 1000 амьд төрөлтөд 34.5 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдэл, гэрийн төрөлт, бүртгэгдээгүй болно. Халдварт өвчин эхний 2 сарын байдлаар 31 буюу 10000 хүн амд 19.8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор буюу Улаанбурхан өвчин дэгдэлт хэлбэрээр гарч өвчлөл нэмэгдсэн байна.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар




Он гарсаар 20744 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5052 хүн буюу 32.1 хувиар, 763 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 70 хүн буюу 10.1 хувиар тус тус өссөн байна.

2016 оны эхний 2 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 1230 удаа гарсан байна. 2016 оны эхний 2 сард осол гэмтлийн өвчлөл 134, халдварт өвчин 31 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Осол гэмтлийн болон халдварт өвчний өвчлөл, жил бүрийн эхний 2 сарын байдлаар




**IV. Гэмт хэрэг**

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 2 сард 29 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8 хэрэг буюу 21.6 хувиар буурсан байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,
жил бүрийн эхний 2 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 8 буюу 38.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 буюу 25.0 хувиар буурч, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 71.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 52.9 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 31 хүн гэмтэж, 4 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 4 буюу 2.0 хувиар буурсан, нас баралт 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,
жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 2 сарын байдлаар 40.8 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 15.9 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 552.7 сая төгрөг буюу 14 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 134.0 сая төгрөг буюу 9 дахин буурсан байна.



2016 оны эхний 2 сард 133 хүн эрүүлжүүлэгдэж, 5 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 12 буюу 8.3 хувь, баривчлагдсан хүний тоо 19 буюу 5 дахин буурсан байна.

Зураг IV.3

Албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан, эрх хасуулсан хүний тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2016 оны 2 сард 105.2 болж өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсч, жилийн эцсээс 0.3 хувиар, өмнөх сараас 0.1 хувь буусан үзүүлэлттэй байна.


Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 2 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2016.II}{2015.II}$	$\frac{2016.II}{2015.XII}$	$\frac{2016.II}{2016.I}$
Ерөнхий индекс	105.2	99.7	99.9
Хүнсний бараа, ундаа, ус	97.8	99.3	100.3
Согтууруулах ундаа, тамхи	97.8	100.3	100.0
Хувцас, бөс бараа, гутал	113.9	100.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.1	100.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.7	100.0	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
Тээвэр	98.4	97.7	97.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.4	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	114.9	100.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.1	100.7	100.0



Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.1 хувиар буурхад тээврийн бүлгийн үнэ 2.3 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 2 дугаар сар, (өмнөх сар=100%)



VI. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 2270.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 2366.6 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 386.4 сая төгрөг буюу 19.5 хувиар өсчээ. Орон нутгийн төсвийн нийт орлого өсөхөд 286.9 сая төгрөгөөр татварын орлого өссөн нь голлон нөлөөлжээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 2460.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1973.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 487.4 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 421.3 сая төгрөг буюу 27.2 хувиар өссөн байна.

2016 оны эхний 2 сарын байдлаар авлагын үлдэгдэл 20.8 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 441.6 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлагын үлдэгдэл 18.7 сая төгрөгөөр буюу 9.9 дахин, өглөгийн үлдэгдэл 324.6 сая төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр




**VII. Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 2 дугаар сард төллөсөн хээлтэгч 569 байна. Эм ямаа 224, эм хонь 177, үнээ 161, гүү 7 төллөжээ. Гарсан төл 85.1 хувь буюу 484 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 158 толгойгоор их байна.

2016 оны эхний 2 сард том малын зүй бус хорогдол 2453 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2421 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 1 мал байна.


Зураг VII.1

Төл бойжилт, жил бүрийн эхний 2 сараар, толгойгоор



Зураг VII.2

Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 2 сараар, толгойгоор

**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 2 сард 9060.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3624.2 сая төгрөг буюу 66.7 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 3583.8 сая төг буюу 72.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 9084.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2361.5 сая төгрөг буюу 35.1 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 8561.6 сая төг буюу 94.2 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,
жил бүрийн эхний 2 сар, сая төгрөгөөр



IX.ТЭЭВЭР


Авто тээврийн газар 2016 оны эхний 2 сарын байдлаар 3.5 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 807.9 мян.хүн км болж 2.0 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

X. ХОЛБОО

Аймгийн Холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 2 сарын байдлаар нийт орлого 34.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1.1 сая төг буюу 3.1 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 20.1 сая төг буюу 56.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 сая төг буюу 5.2 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт телефон цэгийн тоо 369 болж өмнөх оны мөн үеийнхээс 48 буюу 11.5 хувиар буурсан байна.

2016 оны эхний 2 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 16 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 5 байна.

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,
жил бүрийн эхний 2 сар, сая төгрөгөөр





XII. Цаг агаарын мэдээ

2016 оны 2 дугаар сард агаарын дундаж температур -15.5 хэм байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 4.7 хэмээр хүйтэн, хамгийн их температур -0.4 хэм, хамгийн бага температур -27.5 хэм байлаа. Хөрсний температурыг авч үзвэл дундаж нь -15.1 хэм байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 хэмээр бага, хамгийн их нь 2.1 , хамгийн бага нь -33.0 хэм байлаа. Салхины хурд хамгийн ихдээ 11 м/с байсан нь өмнөх оны мөн үеэс 3 м/с-ээр бага байлаа. 3 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур $5-10$ градус хүйтэн байна. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр шөнөдөө $17-22$ градус өдөртөө $6-11$ градус хүйтэн байна. Харин нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд үе гуравдугаар арав хонгийн эхээр шөндөө $10-15$ өдөртөө $0-5$ градус хүйтэн байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч шөнөдөө $3-8$ градус өдөртөө $10-15$ градус дулаан байна. Бусад хугацаанд шөндөө $7-12$ градус хүйтэн өдөртөө $5-10$ градус дулаан байна. Энэ сард Говьсүмбэрийн нутгаар нэг ба гуравдугаар арав хонгийн эхэн ба дунд үеэр бага зэргийн цас орно. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр хур тунадас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үеэр $12-14$ м/с, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр $16-18$ м/с, зарим үед $20-24$ м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй байна.

Бүх нутгаар цастай байгаа ба цаашид үе үе цасан болон шороон шуурга шуурч мал төллүүлэх, малын бэлчээрлэлтэнд таагүй нөлөөлж болзошгүйд онцгой анхаарна уу.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 II	2016 II	Зөрүү	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}} \%$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд					
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	66	58	-8	87.9
Ажил хайгч иргэдийн тоо, 2 дугаар сарын эцэст	хүн	311	254	-57	81.6
Халдварт өвчнөөр өвчлөгчдын тоо	хүн	13	31	18	2.3 дахин
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	37	29	-8	21.6
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт					
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	1980.2	2366.6	386.4	119.5
Татварын орлого	сая.төг	473.0	871.6	398.6	184.3
Татварын бус орлого	сая.төг	38.2	53.5	15.3	140.1
Хөрөнгийн орлого	сая.төг	0.7	-	-	-
Тусламжийн орлого	сая.төг	1506.4	1441.5	-64.9	95.7
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	1551.8	1973.1	421.3	127.1
Бараа үйлчилгээний зардал	сая.төг	1023.0	1690.6	667.6	165.3
Эдийн засгийн үзүүлэлтүүд					
Том малын зүй бусын хорогдол	тол	39	2453	2421	6289.7
- Тэмээ	тол	-	-	-	-
- Адуу	тол	-	53	-	-
- Үхэр	тол	2	118	116	5900
- Хонь	тол	17	901	884	5300
- Ямаа	тол	20	1381	1361	6905
Бойжуулсан төл	тол	411	484	73	117.7
- Тэмээ	тол	-	-	-	-
- Адуу	тол	2	6	4	-
- Үхэр	тол	63	149	86	236.5
- Хонь	тол	240	139	-101	57.9
- Ямаа	тол	106	190	84	179.2
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	5436.2	9060.4	3624.2	166.7
Тээврийн орлого	сая.төг	-	2.0	-	
Холбооны орлого	сая.төг	35.4	34.3	-1.1	96.9



I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Ажил хайгч иргэнийн тоо	311	254	81.6
Үүнээс эмэгтэй	192	146	76.0
Ажлын байрны захиалга	17	34	200.0
Ажилд жуучлагдсан иргэд	10	14	140.0
Үүнээс эмэгтэй	5	8	160.0

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	1216.9	754.1	61.9
Тэтгэврийн даатгалын сангийн	744.6	469.0	63.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	84.9	53.0	62.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	254.6	147.9	58.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	112.9	70.9	62.7
Ажилгүйдлын даатгалын сангийн	20.7	12.3	59.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	1195.7	1386.9	115.9
Тэтгэврийн даатгалын сангийн	919.6	1060.8	115.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	68.5	69.4	101.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	139.3	178.1	127.8
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	49.2	45.6	92.7
Ажилгүйдлын даатгалын сангийн	18.1	31.0	171.2

Тайлбар: *ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 2 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II		2016 II		$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}}\%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	2307	284.0	2023	195.4	87.6	68.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	967	125.3	923	133.2	95.4	106.4
Халамжийн тэтгэвэр	271	62.0	240	65.8	88.5	106.1
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	696	63.3	683	67.3	98.1	106.3
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	447	32.9	459	34.5	102.6	104.8
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	111	11.5	95	11.1	85.6	95.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	116	15.2	114	19.2	98.2	126.3
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	22	3.7	15	2.5	68.1	69.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	1340	158.7	1100	62.3	17.9	2.5 дахин
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	205	8.9	479	30.7	2.3 дахин	3.4 дахин
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	41	2.3	86	9.2	2 дахин	4 дахин
Нийгмийн халамжийн үйлчилгээ	-	-	363	5.6		
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	170	14.0	164	14.4	96.4	102.9
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	10	3.6	7	2.3	70.0	63.8
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	914	130.0	1	1.0	-	-



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}}\%$
Төрсөн эх	67	59	88.0
Амьд төрсөн хүүхэд	66	58	87.9
Эрэгтэй	31	32	103.2
Эмэгтэй	35	26	74.3
Амьгүй төрөлт	1	1	0.0
Нийт нас баралт	17	13	76.4
Эмнэлгийн нас баралт	4	2	50.0
Хоног болоогүй нас баралт	2	0	0.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2	0.0
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2	0.0
Эмчлэгдсэн өвчтөн	693	763	110.1
Амбулаторийн үзлэг	15692	20744	132.2
Осол гэмтлийн өвчлөл	94	134	142.5
Халдварт өвчин	13	31	238.4



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}}\%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	37	29	-21.6
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	21	13	-38.1
Өмчлөх эрхийн эсрэг	12	12	0.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	2	1	0.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	0	1	1 нэгж
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	2	0	2 нэгж
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод	25	26	4.0
14-16 насны	1	1	0.0
16-18 насны	4	5	25.0
18-30 насны	8	10	25.0
30-35 насны	9	8	11.1
35-с дээш	10	6	-40.0
Боловсрол – Дээд	3	5	66.7
Боловсрол - Тусгай дунд	4	1	-75.0
Боловсрол – Бүрэн дунд	8	12	50.0
Боловсрол – Бүрэн бус дунд	7	3	-57.1
Боловсрол – Бага	2	4	100.0
Боловсролгүй	1	1	0.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	2	0.0
Ажилгүй иргэд үйлдсэн	8	16	2 дахин
Эмэгтэй хүн оролцсон	2	4	2 дахин
Хүүхэд оролцсон	1	2	-100.0
Бүлгээр үйлдсэн	2	3	50.0
Согтуугаар үйлдсэн	20	11	-45.0
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	37	29	-21.6
Гудамж талбайд	10	6	-40.0
Албан газарт	1	3	200.0
Гэр орон сууцанд	13	10	-23.1
Авто зам	0	0	0.0
Бусад газарт	13	10	-23.1
ГХ-н улмаас нас барсан	2	4	2 дахин
ГХ-н улмаас гэмтсэн	35	31	2.0
Учирсан хохирол / сая.төг /	593.5	40.8	14.5 дахин буурсан
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	149.9	15.9	9.4 дахин буурсан



V.1 Хэрэглээний үний индекс, 2 дугаар сард, 2016.2, 2015.2, 2015.1 дугаар саруудтай харьцуулснаар

Барааны бүлгээр	2016-2 2015-2	2016-2 2015-12	2016-2 2016-1
Ерөнхий индекс	105.2	99.7	99.9
01. хүнсний бараа, согтууруулах бус ундаа	97.8	99.3	100.3
01.1 хүнсний бараа	97.7	99.2	100.3
01.1.1 талх, гурил, будаа	123.0	100.3	100.1
01.1.2 мах, махан бүтээгдэхүүн	70.7	98.7	103.3
01.1.4 сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	98.9	98.8	99.0
01.1.5 төрөл бүрийн өөх, тос	94.6	100.1	100.0
01.1.6 жимс, жимсгэнэ	96.0	94.8	89.1
01.1.7 хүнсний ногоо	94.1	96.9	100.0
01.1.8 саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколад	93.2	97.9	100.0
01.1.9 хүнсний бусад бүтээгдэхүүн	101.0	102.3	100.0
01.2 согтууруулах бус ундаа	100.1	100.2	100.0
02. согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	97.8	100.3	100.0
02.1 согтууруулах ундаа	101.0	100.9	100.0
02.2 тамхи	96.0	100.0	100.0
03. хувцас, бөс бараа, гутал	113.9	100.0	100.0
03.1 хувцас, бөс бараа	112.9	100.0	100.0
03.1.1 хөвөн, бөс бараа	126.7	100.0	100.0
03.1.2 бүх төрлийн хувцас	112.1	100.0	100.0
03.1.3 жижиг эдлэл, хэрэгсэл	123.0	100.0	100.0
03.2 гутал	116.4	100.0	100.0
04. орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	104.1	100.0	100.0
04.1 орон сууцны бодит түрээс	100.0	100.0	100.0
04.2 орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ	102.3	100.0	100.0
04.3 усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ	100.0	100.0	100.0
04.4 цахилгаан, хийн болон бусад түлш	105.6	100.0	100.0
05. гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.7	100.0	100.0
05.1 гэр ахуйн тавилга, хэрэгсэл, хивс болон шалны бусад дэвсгэр	100.7	100.0	100.0
05.2 гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл	99.2	100.0	100.0
05.3 гэр ахуйн цахилгаан бараа	101.2	100.0	100.0
05.4 гэр ахуйн шилэн эдлэл, сав суулга	122.1	100.0	100.0
05.5 гэр ахуй, цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгсэл	97.5	100.0	100.0
05.6 гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээ	113.9	100.0	100.0
06. эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
06.1 эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл	105.0	100.0	100.0
06.2 амбулторын үйлчилгээ	100.0	100.0	100.0
06.3 эмнэлэгт хэвтэж үзүүлсэн үйлчилгээ	100.0	100.0	100.0
07. тээвэр	98.4	97.7	97.7
07.1 тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.0	100.0	100.0
07.2 хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	95.3	95.4	95.4
07.3 тээврийн үйлчилгээ	104.4	100.0	100.0
08. холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
09. амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.4	100.0	100.0
09.1 дуу, дүрс, гэрэл зураг, мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж	100.9	100.0	100.0
09.2 чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	100.0	100.0	100.0
09.3 ном, сонин, бичгийн хэрэгсэл	100.2	100.0	100.0
10. боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
11. зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	114.9	100.3	100.0
11.1 нийтийн хоолны үйлчилгээ	124.8	100.5	100.0
11.2 зочид буудал дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0	100.0
12. бусад бараа, үйлчилгээ	104.1	100.7	100.0
12.1 хувь хунд хандсан үйлчилгээ	104.9	100.8	100.0
12.2 хувь хүний эд зүйл, хэрэглэл	100.0	100.0	100.0
12.3 санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}} \%$
Орон нутгийн орлого	1980.3	2366.6	119.5
Татварын орлого	473.1	871.6	184.3
Орлогын албан татвар	285.6	531.7	186.2
Өмчийн татвар	9.1	31.7	348.4
Дотоодын бараа үйлчилгээний	-	-	-
Бусад	140.1	308.2	220.0
Татварын бус орлого	38.2	53.5	140.1
Хөрөнгийн орлого	0.7	-	-
Тусламжийн орлого	1506.5	1441.5	95.7

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}} \%$
Бүх зарлага	1551.8	1973.1	127.1
Бараа үйлчилгээний зардал	1023.0	1690.6	165.3
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	528.8	226.5	42.8
Хөрөнгийн зардал	-	56.0	-
Төсөвт байгууллагын тоо	47	51	108.5
Төсөвт байгууллагын ажиллагсадын тоо	751	769	102.4

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 \text{ II}}{2015 \text{ II}} \%$
Авлага	2.1	20.8	990.5
Өглөг	117.0	441.6	377.4



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Бүгд	410	569	138.7
Ингэ	-	-	-
Гүү	2	7	350.0
Үнээ	62	161	259.6
Эм хонь	240	177	73.7
Эм ямаа	106	224	211.3

VII.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Дүн	410	569	138.7
Баянтал	39	298	764.1
Сүмбэр	362	215	59.3
Шивээговь	9	56	622.2

VII.3 ТӨЛ БОЙЖИЛТ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Бүгд	411	484	117.7
Ботго	-	0	-
Унага	2	6	-
Тугал	63	149	236.5
Хурга	240	139	57.9
Ишиг	106	190	179.2

VII.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумдаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Сумд	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Дүн	411	484	117.7
Баянтал	40	276	690
Сүмбэр	362	177	48.9
Шивээговь	9	31	344.4



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Бүгд	39	2453	63 дахин
Тэмээ	-	-	-
Адуу	-	53	-
Үхэр	2	118	59 дахин
Хонь	17	901	53 дахин
Ямаа	20	1381	69 дахин

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Дүн	39	2453	63 дахин
Баянтал	-	634	-
Сүмбэр	36	1483	41 дахин
Шивээговь	3	336	112 дахин

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Бүгд	7	284	40 дахин
Тэмээ	-	-	-
Адуу	-	13	-
Үхэр	1	32	-
Хонь	4	76	19 дахин
Ямаа	2	163	81 дахин

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Дүн	7	284	40 дахин
Баянтал	-	73	-
Сүмбэр	4	77	19 дахин
Шивээговь	3	134	44 дахин



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, жил бүрийн эхний 2 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Нийт	5436.2	9060.4	166.7
Уул уурхай	4953.5	8537.3	172.3
Нүүрс олборлолт	4953.5	8537.3	172.3
Дулааны эрчим хүч, усан хангамж	482.7	523.2	108.4
Дулаан	448.4	447.5	99.8
Усан хангамж	34.3	45.7	133.2

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 2сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Нийт	6723.2	9084.7	135.1
Уул уурхай	6240.5	8561.6	137.2
Нүүрс олборлолт	6240.5	8561.6	137.2
Дулааны эрчим хүч, усан хангамж	482.7	523.2	108.4
Дулаан	448.4	447.5	99.8
Усан хангамж	34.3	45.7	133.2

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Бүтээгдэхүүн борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	6240.5	8561.6	137.2
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	321.2	362.4	112.8
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	248.0	380.8	153.5
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр, сая.төг/	4953.5	8537.3	172.3
Ажиллагсадын тоо	495	595	120.2



IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Тээврийн орлого	Мян.төг	-	2000.2	
Зорчигч эргэлт	Мян.хүн км	-	807.9	
Зорчигчдын тоо	Мян.хүн	-	3.5	
Ажиллагсадын тоо	тоо	-	10	

X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 II	2016 II	$\frac{2016 II}{2015 II} \%$
Нийт орлого	сая.төг	35.4	34.3	96.9
Үүнээс: Хүн амаас	сая.төг	21.2	20.6	97.2
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1273	1244	97.7
Телефон цэг	тоо	417	369	88.5



Е-майл хаяг: govisumber@nso.mn
Вэб хаяг: www.govisumber.nso.mn
Мэдээллийн сангийн хаяг: www.1212.mn
Утас: 70543222, 70543017